

**АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

2026 оны 01 сарын 20

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3 сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Монголын хөрөнгийн биржийн зүгээс 2022 оны 6 сарын 9-ний өдөр үнэлгээний аргачлалыг боловсруулсан.

Компанийн засаглалын кодексийн үнэлгээ нь дараах 9 агуулгаас бүрдэх ба үнэлгээний оноог бүрэн хэрэгжсэн, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, хэрэгжүүлээгүйг үндэслэн 0-2 оноогоор үнэлсэн болно.

Үнэлгээний нэгдсэн дүн

№	Агуулга	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6
5	Эрсдэлийн удирдлага	8	8
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8
8	Компанийн соёл	6	6
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10
	Нэгдсэн дүн	72	71

Ард Кредит ББСБ ХК нь 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Компанийн засаглалын кодексийг 98.6%- тай хэрэгжүүлэн ажиллаж, “Засаглал хэвийн буюу эрсдэлгүй” түвшинд хэмээн үнэлэн тайлагнаж байна.

Компанийн засаглалын үнэлгээний асуулга

Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.

НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 4 дүгээр бүлэгт ТУЗ-ийн гишүүдийн, 5 дугаар бүлэгт хараат бус гишүүдийн, 6 дугаар бүлэгт Нарийн бичгийн даргын, 7 дугаар бүлэгт ТУЗ-ийн даргын чиг үүрэг, хариуцлагыг тус тус нарийвчлан зохицуулсан. https://ardcredit.com/uploads/phpoaR7ZY-1759889151.pdf ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн 29-40 талд тусгасан. https://ardcredit.com/uploads/php7RwRkO-1745492124.pdf ТУЗ-ийн үйл ажиллагааны хагас жилийн тайланг компанийн хагас жилийн тайланд тусган Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлсэн болно. https://mse.mn/issuers/activityreport/550_20250721025121report.pdf 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлсэн.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 3 дугаар бүлэгт ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохицуулсан. https://ardcredit.com/uploads/phpoaR7ZY-1759889151.pdf ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2022/35-01 тоот тогтоолын Хавсралт 2-оор Залгамж халааны бодлогыг баталж, 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдөр бодлогыг шинэчлэн баталсан.	2	100%

			https://ardcredit.com/uploads/phpzUdTnn-1759888992.pdf Компанийн цахим хуудсанд ТУЗ-ийн дарга гишүүдийн туршлага, мэдлэг, эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээллийг тусгаж байршуулсан. https://ardcredit.com/tuz ТУЗ-ийн гишүүдийн 2025 оны ажлын гүйцэтгэл, идэвхийн үнэлгээг тайлангийн хавсралтаар хүргүүлсэн.		
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар бүлэгт ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлсон. https://ardcredit.com/uploads/phpoaR7ZY-1759889151.pdf Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлангийн 34-36 талд ТУЗ-ийн бүтэц, хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тайлан, оролцсон ирц, гишүүдийн үнэлгээг тусгаж, цахим хуудсандаа байршуулсан. https://ardcredit.com/uploads/php7RwRkO-1745492124.pdf ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх хороо хагас жилд нэг удаа ТУЗ-ийн хараат бус гишүүдийн хараат бус байдлыг үнэлдэг бөгөөд жилийн эцэст ТУЗ-ийн гишүүдийн ирц, идэвхийг үнэлэн, ТУЗ-ийн хуралдаанд танилцуулж байна. Компанийн цахим хуудсаар ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага, тэдний эзэмшиж буй хувьцааны тоо, хэмжээг тусгасан танилцуулгыг нээлттэй байршуулсан байдаг. Нээлттэй байршуулсан мэдээллийг энэхүү тайлангийн хавсралтаар хүргүүлсэн. https://ardcredit.com/tuz Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ийн ирц, жилийн үйл ажиллагааны мэдээллийг танилцуулж, хэвшсэн. Танилцуулга:https://ardcredit.com/uploads/phpMMQ6e4-1747216221.pdf	2	100%

			2025 оны жилийн эцсийн тайланд тусган хүргүүлэх болно.		
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь ТУЗ болон хороодын үйл ажиллагааны чиглэл, хороодын бүтэц бүрэлдэхүүн, хорооны эрх үүргийг тодорхойлсон хороодын ажиллах журамтай. Хороодын журамд гишүүдийн ажлын туршлага, мэргэшлийг Компанийн Засаглалын кодекс нийцүүлэн тодорхой заасан байдаг. Хороодын гишүүнчлэл нь хороодын гишүүдийн хүйсийн харьцаа нь 1/3 байхаар журамд зохицуулсан байдаг. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх хороо журмын 2.1-т хорооны бүтэц, 2.2-т хүйсийн тэнцвэрт байдлыг тусгасан. https://ardcredit.com/uploads/phpMIHNfp-1759889037.pdf ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны журмын 2.1-т хорооны бүтэц, 2.2-т хүйсийн тэнцвэрт байдлыг тусгасан. https://ardcredit.com/uploads/phpGcNBeK-1759889102.pdf ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмын 2.1-т хорооны бүтэц, 2.2-т хүйсийн тэнцвэрт байдлыг тусгасан. https://ardcredit.com/uploads/phpvdkrmp-1721889655.pdf	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилохдоо чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ТУЗ-ийн гишүүд нь 3 жилийн хугацаагаар томилогддог бөгөөд жил бүр гишүүд сургалтын төлөвлөгөөг батлан, сургалтанд хамрагддаг болно. ТУЗ-ийн 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 2025/24-2 тоот тогтоолоор ТУЗ-ийн сургалтын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний дагуу 2025 онд ТУЗ-ийн хараат бус гишүүд Компанийн засаглалын төвөөс зохион байгуулсан хэлэлцүүлэг арга хэмжээнд хамрагдсан. Тус арга хэмжээнд дараах агуулгын хүрээнд танилцуулга, хэлэлцүүлэг болсон. Үүнд:	2	100%

			- Нээлттэй компанийн БОНЗ, тайлагнал - Хараат бус гишүүний эрх зүйн байдал тулгамдаж буй асуудал - Компанийн засаглал, мэдээллийн ил тод байдал - МУТС эрсдэлийг удирдахуй Сургалтын төлөвлөгөөний дагуу ТУЗ-ийн ритрийтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, ТУЗ-ийн гишүүд төлөвлөсөн сургалтад хамрагдсан.		
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 6 дугаар бүлэгт ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үүрэг, хариуцлагыг нарийн тодорхойлж өгсөн бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах чиг үүрэгтэй. Үүнд ТУЗ-ийн дарга хариуцлага хүлээнэ гэж заасан. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь жил бүр төлөвлөгөөг батлуулдаг юм. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргын төлөвлөгөөний хэрэгжилтийг Засаглал, нэр дэвшүүлэх хороонд танилцуулсан болно. Хавсралтаар ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын 2025 оны тайланг хүргүүлэв.	2	100%
Дүн				12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээн					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн ТУЗ нь нийт 9 гишүүнтэй ба 3 хараат бус, 6 ердийн гишүүнтэй. ТУЗ-ийн гишүүдийн олонхийг хараат бус болгохоор зорилт тавин ажиллахаар шинэчилсэн хороодын журамд тусгахаар зорин ажиллаж байна.	1	50%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд	Бүрэн хэрэгжүүлсэн	https://ardcredit.com/mn/procs ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Журамд заасны дагуу компанийн Дотоод аудитын хорооны даргаар Хараат бус гишүүн ажилладаг бөгөөд хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох эрхгүй ба шаардлагатай тохиолдолд хүсэлтээр оролцдог.	2	100%

	гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.				
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	https://ardcredit.com/mn/procs ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмыг баталж, ТУЗ-ийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2024/40 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Цалин урамшууллын хорооны даргаар Хараат бус гишүүн ажилладаг. (Гишүүнчлэлийг ТУЗ-ийн 2024.12.17 өдрийн 71 тогтоолоор шинэчилсэн) Хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлаар Компанийн дүрэмд хорооодын тоог 4 болгон нэмэгдүүлэн, цалин урамшууллын хорооны бүрэн эрхийг нэмэлтээр оруулахаар шийдвэрлэсэн. Цалин урамшууллын хорооны журмыг ТУЗ-ийн 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 2025/34 тоот тогтоолоор батлан олон нийтэд мэдээлсэн. Танилцах: https://ardcredit.com/uploads/phpGcNBeK-1759889102.pdf Мөн хорооны хуралд удирдлагын багийн гишүүд оролцох эрхгүй ба шаардлагатай тохиолдолд урилгаар оролцдог.	2	100%
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	https://ardcredit.com/uploads/phpjJfEBK-1721889726.pdf Засаглал, нэр дэвшүүлэх хорооны даргаар Хараат бус гишүүн ажилладаг. (Гишүүнчлэлийг ТУЗ-ийн 2024.12.17 өдрийн 71 тогтоолоор шинэчилсэн).	2	100%
11	2.5. ТУЗ-нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, хороодын чиг үүрэг зэргийг зохицуулдаг бол ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь өөрийн үйл ажиллагааны журмаараа ч хорооны чиг,	2	100%

	хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.		үүрэг, бүтэц, хурлын зохион байгуулалт, шийдвэр гаргалт, гишүүдийн мэргэшил, ажлын туршлага, ажиллах журмыг тодорхойлдог. ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар бүлэгт ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлсон. https://ardcredit.com/uploads/phpoaR7ZY-1759889151.pdf		
Дүн				9	90%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 7 сарын 05-ны өдрийн 2019/15 тоот тогтоолын Хавсралтаар Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журмыг баталсан. https://ardcredit.com/uploads/php7LqaIN-1721889972.pdf Түүнчлэн Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьд Хөрөнгийн бирж ХК-иас баталсан Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмыг баримтлан мэдээллийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлдэг. ТУЗ-ийн дэргэхэд Дотоод аудитын хорооны журамд зааснаар хороо нь олон нийтэд мэдээллийг хүргэж байгаа эсэхэд хяналт тавин ажилладаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн засаглалын кодекстэй холбоотой засаглалын журам, зааврыг компанийн албан ёсны цахим хуудаст байршуулж олон нийтэд хүргэдэг. https://ardcredit.com/procs	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй тодорхой, бодит байна. Санхүүгийн бус	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маягт”-ын дагуу бэлтгэдэг.	2	100%

	тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.		Ард Кредит ББСБ ХК нь “Тогтвортой хөгжлийн тайлангаараа хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилгодоо хүрсэн эсэхээ тайлагнаж оролцогч, хөрөнгө оруулагч талуудадаа цахим сайтаараа болон олон нийтийн сүлжээндээ цахим хуудсаараа мэдээлэлээ хүргүүлдэг.		
			Үйл ажиллагааны тайлангийн 28 талд хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөллийн талаарх тайланг тусгасан.		
			https://ardcredit.com/uploads/php7RwRkO-1745492124.pdf		
			2025 онд Компани Тогтвортой хөгжил, тогтвортой санхүүжилтийг бий болгохоор хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засаг, компанийн засаглалыг сайжруулахыг зорин ажилласан энэ талаар Тогтвортой хөгжлийн 2025 оны тайландаа тусган олон нийтэд мэдээлэн, үйл ажиллагааны тайландаа тусган хүргүүлэх болно.		
Дүн			6	100%	
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	https://ardcredit.com/mn/procs ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хорооны журмыг баталсан. Мөн ТУЗ-ийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/14 тогтоолоор Хөндлөнгийн аудит томилох журмыг баталсан ба уг журмаар хараат бус аудитыг сонгох, томилох харилцааг зохицуулсан бөгөөд Дотоод аудитын хороо нь хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг болно. https://ardcredit.com/uploads/phpvdkrmp-1721889655.pdf	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудит нь жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд аудит тайлан, дүгнэлтээ танилцуулдаг бөгөөд 2025 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд хөндлөнгийн аудит нь тайлан, дүгнэлтээ танилцуулсан.	2	100%

			https://www.facebook.com/watch/live/?ref=searh&v=616230090113127 Хурлын материалын 22-24 талд Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг танилцуулсан. https://ardcredit.com/uploads/phpMMQ6e4-1747216221.pdf		
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Дотоод аудитын тогтолцоо, бүтэц чиг үүргийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд танилцуулдаг. Компанийн цахим хуудсаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг тухай бүр мэдээлдэг. Компанийн дотоод аудитор нь компанийн дүрэмд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан бөгөөд өөрчлөгдөх тухай бүрд СЗХ-ны журамд заасан тохиромжтой этгээдийн шаардлага хангаж байгаа эсэхийг хянуулан бүртгүүлдэг.	2	100%
Дүн				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплаенсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогмтол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн Эрсдэлийн удирдлагын гол чиглүүлэгч нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байх Эрсдэлийн удирдлагын бодлогыг баталж, Зээлийн эрсдэл Зах зээлийн эрсдэл Хөрвөх чадварын эрсдэл Үйл ажиллагааны эрсдэл Комплаенсын эрсдэл Нэр хүндийн эрсдэл Стратегийн эрсдэл 8 төрлийн эрсдэлийг журмаар тодорхойлсон байдаг. Компанийн бүтэцэд Эрсдэлийн удирдлагын газар багтдаг бөгөөд эрсдэлийн удирдлагыг хамгаалалтын 3 шугамаар дамжуулан хэрэгжүүлж байна. ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмын 8 дугаар бүлэгт ТУЗ-ийн бүрэн эрхийг заасан бөгөөд 8.3.2-т Эрсдэлийн удирдлагын болон дотоод хяналтын тогтолцоог зөв зохион байгуулах, мониторинг хийх чиг үүргийг олгосон. https://ardcredit.com/uploads/phpoaR7ZY-1759889151.pdf	2	100%

19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2020/11 тоот тушаалаар ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, Зээл, Эрсдэлийн хорооны журмыг баталсан. Санхүү, Зээл, Эрсдэлийн хорооны журмаар хорооны бүтэц, гишүүдийн тоо, үүрэг, хариуцлага болон хуралдаан зохион байгуулах, шийдвэр гаргах зэрэг хорооны бүх үйл ажиллагааг зохицуулсан. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн 29-40 талд тусгасан. https://ardcredit.com/uploads/php7RwRkO-1745492124.pdf 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусган хүргүүлэх болно.	2	100%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 2022/35/1 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар Ард Кредит ББСБ ХК-ийн Тогтвортой хөгжлийн бодлогыг баталсан бөгөөд Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг бууруулан ажиллаж, жилийн үйл ажиллагааны тайланд компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн боломж нь байгаль орчин болон харилцагчид хэрхэн нөлөөлж буй тоон үзүүлэлтийг хүргэдэг. Ард Кредит ББСБ ХК нь “Тогтвортой хөгжлийн тайлангаараа хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилгодоо хүрсэн эсэхээ тайлагнаж оролцогч, хөрөнгө оруулагч талуудадаа цахим сайтаараа болон олон нийтийн сүлжээндээ цахим хуудсаараа мэдээлэлээ хүргүүлдэг. СЗХ-ноос баталсан БОНЗ-ийн үнэлгээний дагуу БОНЗ-ийн үнэлгээг бэлтгэн олон нийтэд мэдээлэн ажиллаж байна.	2	100%
21	5.4. Компани нь комплаенсын	Бүрэн хэрэгжүүлсэн	Комплаенсын хяналтыг комплаенс хариуцсан мэргэжилтэн нь хяналтын	2	100%

	хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплаенсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.		тогтолцоог хэрэгжүүлдэг. ТУЗ нь Комплаенс хариуцсан мэргэжилтний хараат бус байдлыг хангуулах үүднээс ТУЗ-өөс томилон ажиллуулдаг бөгөөд ТУЗ-ийн 2025/32 тоот тогтоолоор комплаенс хариуцсан мэргэжилтэнг томилсон. Тогтоолыг тайлангийн хавсралтаар хүргүүлэв. Комплаенс хариуцсан мэргэжилтэн нь ТУЗ-д улирал бүр хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнаж, ТУЗ-өөс хяналт тавин ажилладаг.		
Дүн				8	100%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ баталдаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүний цалин, урамшуулал, тухайн жилийн төсвийг нээлттэй танилцуулж хэвшсэн болно. 2025 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн дүрмийн 8.1.3 дахь заалтад өөрчлөлт оруулж ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллыг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн цалин, урамшууллыг тогтоож батлах зохицуулалтыг оруулж, компанийн засаглалыг сайжруулалаа. 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанаар ТУЗ-ийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах болно.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь Группын цалин урамшууллын бодлогыг үйл ажиллагаандаа мөрддөг бөгөөд уг бодлогоор цалин, урамшууллын хэмжээг тогтоох, үнэлэх харилцааг зохицуулсан байдаг. ТУЗ нь жил бүрийн эхний улиралд ажлын гүйцэтгэлийг үнэлж, ирэх жилийн гүйцэтгэлийг бодлого журамд нийцүүлэн баталдаг.	2	100%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд өнгөрсөн санхүүгийн жилд гаргасан компанийн санхүү болон үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг тусгахаас гадна	2	100%

	удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.		Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал, урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгадаг бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд гүйцэтгэх захирлын цалин урамшууллыг нээлттэй танилцуулсан. https://ardcredit.com/uploads/phpMMQ6e4-1747216221.pdf 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусган хүргүүлэх болно.		
Дүн				6	100%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн биелүүлсэн	https://ardcredit.com/uploads/phpdaM8DR-1721889894.pdf Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 2024/23 тоот тогтоолоор Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг тус тус баталсан. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 7 сарын 05-ны өдрийн 2019/15 тоот тогтоолын Хавсралтаар Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журмыг баталсан. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангахыг “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам ” -аар зохицуулж байна.	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	https://ardcredit.com/mn/reports Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан, улирал бүрийн тайланг хувьцаа эзэмшигчдэд нээлттэй хүргэж хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, ажилтан болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, ажлын талаарх мэдээллийг өөрсдийн Цахим хуудсаар болон Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан нээлттэй танилцуулдаг. 2024 онд улирал бүр Цахим хуудсаараа дамжуулан Гүйцэтгэх удирдлагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар шууд танилцуулга хийж, оролцогч талуудын санал хүсэлтийг хүлээн авч, үйл ажиллагааны тусган ажиллаж байна.	2	100%

			2025 оны жилийн үйл ажиллагааны тайланд тусган хүргүүлэх болно.		
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны www.ardcredit.com цахим хуудас болон сошиал хуудсыг тогтмол ажиллуулж, компанийн засаглал, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хамтран ажиллаж буй байгууллагууд болон компанийн үйл ажиллагаанд гарсан онцлог үйл явдлуудын талаарх мэдээллийг харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудад тогтмол хүргэж мэдээллээр ханган ажиллаж байна.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Гүйцэтгэх захирлын 2022 оны 04 дугаар сарын 28-ны өдрийн 22/А/25 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан Хөдөлмөрийн Дотоод журамд ажилтны гомдол, саналыг хүлээн авах, шийдвэрлэх харилцааг нарийн зохицуулсан ба ажилтны нийгмийн асуудал болон мэргэжил, дээшлүүлэх сургалт, хөгжил, карьер төлөвлөлтийн асуудлыг мөн тусгайлан зохицуулсан байна. Компани хамтдаа хуваалцаж, тогтвортой хөгжих үнэт зүйлийн дор ажилтнуудаа хөгжиж, мэргэшүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан тодорхой хэмжээний сургалтын төлбөрийн урамшууллыг олгоод байна.	2	100%
Дүн				8	100%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 2022/21 тоот тогтоолоор Компанийн Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагаанд илэрсэн аливаа хууль бус үйлдэл, зөрчлийн талаарх мэдээллийг Комплаенс хариуцсан мэргэжилтэн холбогдох зөрчлийн хамрах хүрээний хувьд хүний нөөц, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн	2	100%

	үлээгчийн” тогтолцоотой байна.		дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд, санхүүгийн тайлагнал, залилантай холбоотой асуудлыг Дотоод аудитын хороонд, зээл, эрсдэлтэй холбоотой асуудлыг Санхүү, Зээл, Эрсдэлийн хороонд тус тус мэдэгдэж ажиллаж байна.		
31	Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх/өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 2022/21 тоот тогтоолоор Компанийн Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2	100%
Дүн				6	100%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдий эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны www.ardcredit.com сайт, цахим хуудас болох “Ard Credit” Facebook хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, зээлдэгч, холбогдох төрийн байгууллага зэрэг бүх оролцогч талуудад зориулсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 2024/23 тоот тогтоолоор Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах, Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг тус тус баталсан. Хувьцаа эзэмшигчидэдээ компанийн мэйл хаяг, цахим хуудас, цахим хаяг, компанийн 77003322 дугаараар дамжуулан тэдний санал хүсэлтийг хүлээн авч байна. 2025 онд улиралд нэг удаа хувьцаа эзэмшигчидтэй уулзах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.	2	100%
34	9.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг жил бүр хуульд заасан хугацаанд зохион байгуулж байна. Хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд ТУЗ -өөр батлуулан хувьцаа эзэмшигчдэд жилийн үйл ажиллагааны тайлангийн хамт хүргүүлж, тэдний санал	2	100%



	бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.		өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь бүрэн мэдээллээр хангаж, хууль ёсны эрх ашгийг нь хүндэтгэн ажиллаж байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар асуулт асууж хариулт авах, санал, гомдол, хүсэлтээ илэрхийлэх бүрэн боломжоор ханган ажиллаж байна.		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөх, нэмж хувьцаа гаргах, сонирхлын зөрчилтэй их хэмжээний хэлцэл хийх, компанийн өрийг хувьцаагаар солих зэрэг хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн бүтэцтэй холбоотой шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг бөгөөд хэрэв сонирхлын зөрчилтэй асуудал хэлэлцвэл санал хураалтад зөвхөн сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчид оролцдог.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх тайланд оруулах найруулгыг албаны хэлбэрт оруулан сайжруулбал: Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 2019/14 тоот тогтоолоор “Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журам”-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус журамд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлдэг үйл ажиллагааны тайланд тухайн тайлант хугацаанд хамаарах сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн талаарх мэдээллийг тусган хүргүүлж хэвшсэн. 2025 онд нийт 24 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд эдгээр хэлцлийн нийт дүн 12,183,209,955 төгрөг байна.	2	100%
Дүн				10	100%
Нэгдсэн дүн				71	98.6%
Тайлан бэлтгэн, хүргүүлсэн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин 2026.01.20					